



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 5/07

Бор-Өндөр

Ур чадварын нэмэгдэл,
шагнал урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Соёлын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны А/166, А/63, А/73 дугаар хамтарсан тушаал, Байгууллагын дотоод журмын 7.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус байгууллагын хөгжмийн багш А.Тэргэл, номын санч Д.Гантогоо, үйлчлэгч Ц.Баярмаа нарт 2025 оны 1 дүгээр улирлын ажлын үр дүнгийн үнэлгээг үндэслэн ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тооцож олгосугай.

2.Бүжгийн багш З.Батзоригийн Сүйн гэгээ, Хүн домог улсын уралдаанд гаргасан амжилтыг үнэлж үндсэн цалингийн 25 хувиар шагнаж урамшуулсугай.

3.Ажилтнуудад ур чадварын нэмэгдлийг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 06 сарын 30-ны өдөр хүртэл сар бүр дээрх хувиар тооцох, шагнал урамшууллыг 2025 оны 04 сарын цалин дээр бодож олгохыг ня-бо (М.Мөнхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



М.ЧУЛУУНЦЭЦЭГ



Соёлын төвийн даргын
... оны ... дүгээр сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт

Ур чадварын нэмэгдэл олгох албан хаагчдын нэрс

№	Албан хаагчийн нэр	Албан тушаал	Улирлын ажлын үнэлгээ	Үндсэн цалингийн хувь
1	А.Тэргэл	Хөгжмийн багш	98	25%
2	Д.Гантогоо	Номын санч	90	25%
3	Ц.Баярмаа	Үйлчлэгч	90	25%